



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/149

Халбан

Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4 дэх заалт, 9.4.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/510 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрхээр багийн орчим 5 км дотор нийтийн эдэлбэр газар үүссэн хог хаягдлыг бүх нийтээрээ цэвэрлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 29, 30-ны өдөр зохион байгуулж ажилласугай.

2. Бүрхээр багийн нутагт цэвэрлэх талбайн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулж удирдлага арга зүйгээр хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дамжинрагчаа (Бүрхээр багийн Засаг дарга)

Гишүүдэд: Л.Дамдинсүрэн (Байгаль хамгаалагч)

Б.Дашренчин (Байгаль хамгаалагч)

Ч.Цог-Эрдэнэ (Ренчинжугнай багийн Засаг дарга)

Д.Баясгалан (Уранхайрхан багийн Засаг дарга)

Ө.Хүчитбаатар (Могойн гол ХК-ын дэд захирал)

З.Бямбасүрэн (Могойн гол ХК-ын байгаль орчны мэргэжилтэн)

4. Бүрхээр багт үйл ажиллагаа явуулдаг төрийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшил, Бүрхээр багт оршин суугч өрх бүрээс 1-ээс доошгүй иргэнийг хамруулан бүх нийтийн хог цэвэрлэгээг үр дүнтэй, чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Дамжинрагчаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР